

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/72/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2025 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Одбилэг

Утас: 70272582 Цахим хаяг: odbilegb@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТЭЛ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн Хурал
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 41100, Төв аймаг, Зуунаст сум Утас: 70272582, Үндэсний хууль: nyv.aimiti.gov.mn Хуудас: www.audit.mn	ТӨВ АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Д.БАТЦЭЦЭГ ТАНАА
2025.08.25 № 01/63	
Тамгай _____ -ны № _____ -т	
Хязгаарлалттай дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p> <p>Тайлант онд тус байгууллага нь цалингийн зардалтай холбоотой 62,969.2 мянган төгрөг, бараа материалтай холбоотой 43,963.9 мянган төгрөг, үндсэн хөрөнгөтэй холбоотой 57,360.2 мянган төгрөг нийт 164,293.3 мянган төгрөгийн зөрчил гаргасан нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.</p> <p>Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "оршин байх", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.</p>	
412506488	

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд 1,060,018.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн төсвийн хөрөнгөөр болон үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Тайлант хугацаанд төсөвт тодотгол хийгдэж 2024 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 05 дугаар тогтоолоор 359,484.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 974,694.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 47 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулан баталснаас хэрэгжилт 95,6 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	138,854,838.0	182,818,798.0
33	АВЛАГА	1,750,400.0	1,750,400.0
335	Бусад авлага	1,750,400.0	1,750,400.0
3351	Байгууллагаас авах авлага	1,750,400.0	1,750,400.0
35	БАРАА МАТЕРИАЛ	137,104,438.0	181,068,398.0
351	Түүхий эд материал	180,000.0	180,000.0
35130	Эм боох материал	180,000.0	180,000.0
354	Хангамжийн материал	104,519,438.0	148,483,398.0
35410	Бичиг хэргийн материал	4,815,575.0	4,294,175.0
35420	Аж ахуйн материал	86,901,713.0	110,431,842.0
35440	Түлш, шатах тослох материал	0.0	2,274,181.0
35470	Бусад хангамжийн материал	12,802,150.0	31,483,200.0
35600	Мал амьтад	32,405,000.0	32,405,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,263,141,622.4	3,129,278,452.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,263,141,622.4	3,129,278,452.9
392	Биет хөрөнгө	2,260,057,622.4	3,113,700,452.9
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,399,609,173.2	2,234,631,248.2
39202	Хуримтлагдсан элэгдэл	-79,536,564.8	-127,947,936.2
39203	Авто-тээврийн хэрэгсэл	343,777,521.0	343,777,521.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-117,873,584.6	-153,907,111.3
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	148,057,660.0	176,634,165.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-51,975,539.7	-78,299,032.2
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,318,325.0	87,608,085.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,708,229.2	-30,229,356.6
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,034,095,472.0	1,185,731,952.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-444,706,610.7	-524,299,082.0
393	Биет бус хөрөнгө	3,084,000.0	15,578,000.0
39301	Программ хангамж	2,035,000.0	2,035,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,285,000.0	-1,285,000.0
39303	Бусад биет бус хөрөнгө	2,334,000.0	14,828,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,401,996,460.4	3,312,097,250.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,467,125.0	3,268,000.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,467,125.0	3,268,000.0
413	Өглөг	3,467,125.0	3,268,000.0
4136	Бусад өглөг	3,467,125.0	3,268,000.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	3,467,125.0	3,268,000.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,398,529,335.4	3,308,829,250.9
51	Засгийн газрын хувь оролцоо	2,398,529,335.4	3,308,829,250.9
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	477,550,843.0	477,550,843.0
51101	Өмч: - төрийн	477,550,843.0	477,550,843.0
512	Хуримтлагдсан үр дүн	1,618,450,846.7	2,528,750,762.2
51210	Өмнөх үеийн үр дүн	1,618,450,846.7	1,618,450,846.7
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	910,299,915.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	302,527,645.7	302,527,645.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,401,996,460.4	3,312,097,250.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,778,717,819.7	2,437,752,007.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	632,972,590.7	1,003,213,555.0
120	Нийтлэг татварын бус орлого	632,972,590.7	1,003,213,555.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	632,972,590.7	1,001,152,555.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	21,024,491.7	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,145,745,229.0	1,434,538,452.7
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	271,672,951.0	161,045,852.7
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	104,000.0	10,000,000.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	51,365,457.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	242,811,691.0	58,127,674.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	28,757,260.0	41,552,721.7
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	874,072,278.0	1,273,492,600.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	874,072,278.0	1,273,492,600.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	993,733,971.4	1,527,452,092.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	982,618,671.4	1,463,204,378.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	833,687,345.5	1,294,430,464.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	372,864,577.0	707,703,908.5
210101	Үндсэн цалин	247,944,463.7	461,435,089.5
210102	Нэмэгдэл	79,621,483.5	209,510,440.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,167,065.0	17,906,773.0
210104	Урамшуулал	34,000,139.6	18,851,605.5
210105	Гэрээт ажлын хөлс	7,131,425.2	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,390,302.8	0.0
210201	Тэтгэврийн даатгал	31,693,859.1	0.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,728,689.5	0.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,289,748.8	0.0
210204	Ажилгүйдлийн даатгал	693,338.8	0.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6,984,666.6	0.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,941,195.5	48,902,097.9
210301	Гэрэл, цахилгаан	4,767,743.0	5,869,044.9
210302	Түлш, халаалт	41,173,452.5	43,033,053.0
2104	Хангамж, бараа материалын зардал	51,933,986.0	70,527,840.0
210401	Бичиг хэрэг	4,901,120.0	5,772,430.0
210402	Тээвэр, шатахуун	25,813,466.0	46,093,235.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,186,500.0	2,377,100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,032,900.0	16,285,075.0
2105	Норматив зардал	577,650.0	2,489,249.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	577,650.0	2,489,249.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,205,282.0	26,278,032.0
210604	Урсгал засвар	21,205,282.0	26,278,032.0
2107	Томилолт, зочны зардал	5,364,000.0	15,090,000.0
210702	Дотоод албан томилолт	5,364,000.0	15,090,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,602,276.5	5,111,140.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,658,331.5	3,959,140.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,500,000.0	720,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	96,525.0	0.0

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	325,420.0	432,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.0	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	234,808,075.7	418,328,197.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	84,831,412.0	224,446,207.6
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	149,976,663.7	193,881,989.5
211	ХҮҮ	0.0	1,740,000.0
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	0.0	1,740,000.0
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	0.0	1,740,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	148,931,326.0	167,033,914.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,200,000.0	50,783,646.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.0	4,326,700.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	24,297,600.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	22,096,596.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,200,000.0	62,750.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	145,731,326.0	116,250,268.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	145,731,326.0	116,250,268.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,115,300.0	64,247,713.4
2200	Дотоод эх үүсвэрээр	11,115,300.0	64,247,713.4
221001	Их засвар	2,000,000.0	0.0
223001	Бусад хөрөнгө	9,115,300.0	64,247,713.4
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	784,983,848.3	910,299,915.5
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	427,000.0	0.0
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	427,000.0	0.0

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,166,769,720.7	1,434,538,452.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,024,491.7	0.0
120	Нийтлэг татварын бус орлого	21,024,491.7	0.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,024,491.7	0.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	21,024,491.7	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,145,745,229.0	1,434,538,452.7
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	271,672,951.0	161,045,852.7
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	104,000.0	10,000,000.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	51,365,457.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	242,811,691.0	58,127,674.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	28,757,260.0	41,552,721.7
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	874,072,278.0	1,273,492,600.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	874,072,278.0	1,273,492,600.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,049,504,520.7	1,324,408,074.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,049,504,520.7	1,324,408,074.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	901,273,194.7	1,153,155,610.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	376,771,541.7	635,438,261.1
210101	Үндсэн цалин	253,761,611.1	354,866,112.7
210102	Нэмэгдэл	80,413,640.5	242,326,739.9

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,085,945.0	19,393,803.0
210104	Урамшуулал	31,601,929.0	18,851,605.5
210105	Гэрээт ажлын хөлс	6,908,416.2	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,307,045.9	69,106,647.4
210201	Тэтгэврийн даатгал	31,601,740.1	47,035,798.4
210202	Тэтгэмжийн даатгал	3,797,696.4	5,731,028.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,252,196.7	2,858,290.9
210204	Ажилгүйдлийн даатгал	716,816.5	2,727,072.8
210205	Эрүүл мэндийн даатгал	6,938,596.2	10,754,456.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,941,195.5	48,902,097.9
210301	Гэрэл, цахилгаан	4,767,743.0	5,521,551.3
210302	Түлш, халаалт	41,173,452.5	43,380,546.6
2104	Хангамж, бараа материалын зардал	30,103,174.0	39,859,730.0
210401	Бичиг хэрэг	2,931,900.0	2,625,900.0
210402	Тээвэр, шатахуун	24,858,174.0	34,836,730.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,313,100.0	2,397,100.0
2105	Норматив зардал	1,000,000.0	10,219,800.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.0	10,219,800.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,300,000.0	37,077,690.0
210604	Урсгал засвар	6,300,000.0	37,077,690.0
2107	Томилолт, зочны зардал	5,364,000.0	15,090,000.0
210702	Дотоод албан томилолт	5,364,000.0	15,090,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,937,414.6	8,277,956.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,417,994.6	7,125,956.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,824,000.0	720,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.0	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	325,420.0	432,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	170,000.0	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	338,548,823.0	289,183,427.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	338,548,823.0	289,183,427.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	148,231,326.0	171,252,464.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,500,000.0	55,002,196.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.0	6,608,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	24,297,600.0
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	22,096,596.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.0	2,000,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	145,731,326.0	116,250,268.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	145,731,326.0	116,250,268.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	117,265,200.0	110,130,378.4
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	117,265,200.0	110,130,378.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	117,265,200.0	110,130,378.4
2200	Дотоод эх үүсвэрээр	117,265,200.0	110,130,378.4
223001	Бусад хөрөнгө	0.0	51,264,113.4
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	117,265,200.0	58,866,265.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-117,265,200.0	-110,130,378.4
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	477,550,843.0	302,527,645.7	831,289,598.4	1,611,368,087.1
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	477,550,843.0	302,527,645.7	831,289,598.4	1,611,368,087.1
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	785,410,848.3	785,410,848.3
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	477,550,843.0	302,527,645.7	1,618,450,846.7	2,398,529,335.4
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	477,550,843.0	302,527,645.7	1,618,450,846.7	2,398,529,335.4
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	477,550,843.0	302,527,645.7	1,618,450,846.7	2,398,529,335.4
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	910,299,915.5	910,299,915.5
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	477,550,843.0	302,527,645.7	2,528,750,762.2	3,308,829,250.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,201,296,900.0	1,119,066,234.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,201,296,900.0	1,119,066,234.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,168,391,300.0	1,086,160,634.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	603,141,800.0	589,597,863.2
210101	Үндсэн цалин	357,214,100.0	354,866,112.7
210102	Нэмэгдэл	211,947,300.0	196,486,342.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,000,000.0	19,393,803.0
210104	Урамшуулал	15,980,400.0	18,851,605.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,392,700.0	63,407,005.7
210201	Тэтгэврийн даатгал	51,267,000.0	43,108,417.4
210202	Тэтгэмжийн даатгал	6,031,400.0	5,271,196.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,015,700.0	2,628,369.8
210204	Ажилгүйдлийн даатгал	3,015,700.0	2,510,964.2
210205	Эрүүл мэндийн даатгал	12,062,900.0	9,888,057.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,018,200.0	48,902,097.9
210301	Гэрэл, цахилгаан	5,854,600.0	5,521,551.3
210302	Түлш, халаалт	53,063,600.0	43,380,546.6
210303	Цэвэр, бохир ус	100,000.0	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	30,573,900.0	30,573,010.0
210401	Бичиг хэрэг	2,550,000.0	2,625,900.0
210402	Тээвэр, шатахуун	25,623,900.0	25,550,010.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.0	2,397,100.0
2105	Норматив зардал	12,320,000.0	12,319,800.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,320,000.0	12,319,800.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,640,000.0	43,637,690.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.0	2,500,000.0
210604	Урсгал засвар	41,140,000.0	41,137,690.0
2107	Томилолт, зочны зардал	14,072,000.0	14,070,000.0
210702	Дотоод албан томилолт	14,072,000.0	14,070,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,260,000.0	13,901,600.0

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,750,000.0	5,749,600.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.0	720,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.0	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,140,000.0	432,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	250,000.0	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,000,000.0	7,000,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	313,972,700.0	269,751,567.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	313,972,700.0	269,751,567.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,905,600.0	32,905,600.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,905,600.0	32,905,600.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,608,000.0	6,608,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,297,600.0	24,297,600.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.0	2,000,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	66,157,699.4
2200	Дотоод эх үүсвэрээр	0.0	66,157,699.4
223001	Бусад хөрөнгө	0.0	66,157,699.4
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.0	1,273,492,600.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	1,273,492,600.0
132001	Орон нутгийн төсвөөс	0.0	1,273,492,600.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	23
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8
620003	Үйлчлэх ажилтан	7	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	283,080,577.50	161,045,852.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	121,029,495.50	133,064,250.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	112,149,361.00	110,967,654.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	66,384,060.00	45,840,397.90
210102	Нэмэгдэл	66,384,060.00	45,840,397.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,669,758.00	5,699,641.60
210201	Тэтгэврийн даатгал	5,171,234.00	3,927,381.00
210202	Тэтгэмжийн даатгал	663,854.00	459,831.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	331,963.00	229,921.00
210204	Ажилгүйдлийн даатгал	300,567.00	216,108.50
210205	Эрүүл мэндийн даатгал	1,202,140.00	866,399.30
2104	Хангамж, бараа материалын зардал	9,123,210.00	9,316,720.00
210401	Бичиг хэрэг	715,676.80	0
210402	Тээвэр, шатахуун	8,407,533.20	9,316,720.00
2107	Томилолт, зочны зардал	3,492,000.00	1,020,000.00
210702	Дотоод албан томилолт	3,492,000.00	1,020,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,433,333.00	1,376,356.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,433,333.00	1,376,356.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,047,000.00	47,714,539.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,047,000.00	47,714,539.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,880,134.50	22,096,596.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,754,979.50	22,096,596.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,754,979.50	22,096,596.00

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	125,155.00	0.0
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	125,155.00	0.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	162,051,082.00	0.0
2200	Дотоод эх үүсвэрээр	162,051,082.00	0.0
223001	Бусад хөрөнгө	162,051,082.00	0.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	283,080,577.50	161,045,852.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	283,080,577.50	161,045,852.70
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.0	10,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	252,520,782.50	51,365,457.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,559,795.00	58,127,674.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.0	41,552,721.60

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлангийн аудитаар 133,423.9 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлснийг дараах байдлаар шийдвэрлэлээ.

1.1 Залруулсан алдаа

- Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн уялдааг шалгаж үзэхэд мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг 120,929.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.
- Тус байгууллага нь 5,494.0 мянган төгрөгийн үнэтэй газар эзэмших эрхийг Засгийн газрын 2018 оны 182-р тогтоолын дагуу газрын суурь үнэлгээгээр тооцож биет бус хөрөнгийн дансанд бүртгэж тайлагнаагүй байна.
- Тус байгууллага нь "Ухаалаг засаглал НҮТББ"-тай гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим сан нэвтрүүлэх, ашиглалт үйлчилгээний гэрээ хийж 7,000.0 мянган төгрөгийг холбогдох зардлаас шилжүүлсэн боловч данс бүртгэлд тусгаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 164,293.3 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 155,399.8 мянган төгрөгөөр их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

1.2 Залруулаагүй алдаа

Аудитаар нийт 125,724.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2,209.6 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 66,154.6 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, хариуцлага тооцох албан шаардлага 1, 1 зөрчилд зөвлөмж өгч ажиллалаа.

5.2.1 Төлбөрийн акт

1.Илрүүлэлт: Тус байгууллага нь Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу тайлант онд 3 албан хаагчид 22,096.6 мянган төгрөгийн хөдөө орон нутагт тогтвор

¹ Мэдээллийг тусгаагүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх

суурьшилтай ажилласан албан хаагчид урамшуулал олгохдоо 10 хувь болох 2,209.6 мянган төгрөгийн ХХОАТ суутган тооцоогүй зөрчил байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, ХХОАТ-ын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дахь хэсэгт “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол төлбөрийн акт тогтооно гэсний дагуу шийдвэрлэв.

5.2.3 Албан шаардлага

1.Илрүүлэлт: Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад 29 мэдээллийг хугацаа хоцроож, 8 мэдээллийг огт мэдээлээгүй ба өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн биелэлт хангалтгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.2-т Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” хүргүүлнэ гэж заасны дагуу шийдвэрлэв.

2.Илрүүлэлт: Тайлант онд олгосон цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг нийгмийн даатгалд тайлагнахдаа 11, 12 дугаар саруудад нийт 20,025.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан зөрчил байна. Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.28-д “Энэ хуулийн 7.7-д заасан даатгуулагчийн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуульд заасны дагуу нийгмийн даатгалын зохих санд төлж болно”, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн бол албан шаардлага өгнө” гэсний дагуу шийдвэрлэв.

3.Илрүүлэлт: Тайлант онд олгосон цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг ХХОАТ-ын тайланд тайлагнахдаа 40,733.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан зөрчил байна. Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д “Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, 25 дугаар зүйлийн 25.4-т “Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа,

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн бол албан шаардлага өгнө” гэсний дагуу шийдвэрлэв.

4.Илрүүлэлт: Тайлант онд бараа материалын дансны үлдэгдэл 137,104.4 мянган төгрөг байсан ба жилийн эцэст 181,068.4 мянган төгрөг болж 43,963.9 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн бол албан шаардлага өгнө” гэсний дагуу шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр болон үнэ төлбөргүй хүлээн авсан 50 нэр төрлийн 57,360.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацааг дагаж мөрдөөгүй зөрчил байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1-т "Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийг орлогоор хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгахдаа холбогдох хууль, журмыг үндэслэн элэгдэл тооцоход баримтлах хугацааг дагаж мөрдөх, цаашид уг алдаа зөрчлийг гаргахгүй байх, дотоод хяналтаар хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгаж биелэлтийг дүгнэж хэвших

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлагналтай холбоотой алдаа	3	133,423.9	2	12,494.0	1	120,929.9	3	133,423.9				
Дүн	3	133,423.9	2	12,494.0	1	120,929.9	3	133,423.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ХХОАТ-ыг суутган тооцоогүй.	1	2,209.6	1	2,209.6								
Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг баримтлаагүй.	1	57,360.2					1	57,360.2				
НДШ-ийг зөрүүтэй тайлагнасан.	1	20,025.8			1	20,025.8						
ХХОАТ-ыг дутуу тайлагнасан.	1	40,733.8			1	40,733.8						
Хариуцлага тооцох албан шаардлага /Шилэн данс/	1								1	1		
Дүн	5	120,329.4	1	2,209.6	2	60,759.6	1	57,360.2	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн биелэлт хангалтгүй зөрчлийг давтан гаргасан.	1								1	1
Дүн	1								1	1
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа материал нөөцөлсөн.	1	43,963.9			1	43,963.9				
Дүн	2	43,963.9			1	43,963.9			1	1

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn